



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАНШААРДЛАГА

2018 оны 06 сарын 25 өдөр

Дугаар СА-04/2018-ТА

Сүхбаатар

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 12-р сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Сүхбаатар суманд эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- 235,0 сая төгрөгийн өртөг бүхий 18 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээний хуудсаар үнэлж, баримтжуулаагүй,
- 20,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Сүхбаатар сумын барилгын 27-р байрыг хэрэглээний халуун усны шугамд холбох", 20,0 сая төгрөгийн төсөв өртөг бүхий "Сүхбаатар сумын 1-р сургуулийн дотуур байрны засвар" зэрэг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэх хуудас хүргүүлээгүй,
- 80,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сүхбаатар сумын 7-р баг төмөр замын байруудыг хэрэглээний халуун усаар хангах зорилгоор зуух угсрах", 20,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сүхбаатар сумын 7-р багийн дулаан хуваарилах төвийн засвар" зэрэг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан "Эко партнерс" ХХК-ийг сонгон шалгаруулсан,
- 2,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Хог хураамжийн бүртгэл, тооцооны програм авах" төсөл, арга хэмжээг хүлээн авсан комиссын акт гараагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон зэрэг нийт 377.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Эдгээр нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 12.1 дэх "Тендерт ороолцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавхи болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлана", 33.2 дахь "Харьцуулалтын аргыг дараах байдлаар хэрэглэнэ: 33.2.1. Техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх", Барилгын тухай хуулийн 14.1 дэх "Барилга байгууламжийн зураг төсөл, барилгын ажил, материал үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд

ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ”, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын журмын 4.5 дахь “дараах материалыг үндэслэн ажлын 2 хоногийн дотор санхүүжүүлнэ: 4.5.10. Барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсан тухай комиссын акт, тоног төхөөрөмж хүлээн авсан акт” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.7-д “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь :**

1. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа шаардлага хангасан 3 буюу түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэл хүргүүлэх.
2. Тендерийн баримт материалыг үнэлгээний хуудсаар үнэлж, баримтжуулж байх.
3. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг холбогдох журмын дагуу олгох.
4. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сүхбаатар сумын Засаг дарга Т.Гантулга, ЗДТГ-ын дарга Э.Нандин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

С.БААСАНСҮРЭН

ЗӨВШӨӨРСӨН:

СҮХБААТАР СУМЫН ЗАСАГ ДАРГА
Т.ГАНТУЛГА

СҮХБААТАР СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА

Э.НАНДИН-ЭРДЭНЭ

Акт, албан шаардлагын бүртгэл, хяналтын хуудас

Акт /албан шаардлага/ тогтоох үеийн бүртгэл, хяналт

1. Үндсэн мэдээлэл

Аудитын нэр	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн	Аудитын код	СЭАГ-2018/01-ГА		
Акт /албан шаардлага/-ын дугаар	СЭА-01/02-ГА	Тогтоосон огноо	2018.06.25	Мөнгөн дүн /төгрөгөөр/	377,400,000.00

Акт /албан шаардлага/ тогтоосон үндэслэл	Зөрчил дутагдлыг товч тодорхойлж бичих		Төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгох шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээний хуудсаар үнэлж, баримтжуулаагүй, 40,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэх хуудас хүргүүлээгүй, 80,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сүхбаатар сумын 7-р баг төмөр замын байруудыг хэрэглээний халуун усаар хангах зорилгоор зуух угсрах", 20,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сүхбаатар сумын 7-р багийн дулаан хуваарилах төвийн засвар" зэрэг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан "Эко партнерс" ХХК-ийг сонгон шалгаруулсан, 2,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Хөг хураамжийн бүртгэл, тооцооны програм авах" төсөл, арга хэмжээг хүлээн авсан комиссын акт гараагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон зэрэг нийт 377,4 сая төгрөгийн зөрчил илэрлээ		
		Нэр	ТБОНӨХБАУХА тухай хууль		
		Заалт	12.1 болон 33.2 дахь заалт		
		Нэр	Барилгын тухай хууль		
		Заалт	14.1 дэх заалт		
		Нэр	Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"		
		Заалт	4.5 дахь заалт		
	Акт /албан шаардлага/ тогтоох эрх зүйн үндэслэл	Нэр	Төрийн аудитын тухай хууль, МУЕА-ын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"		
		Заалт	Хуулийн 15.1.12, журмын 3.1.7		

Актын төлбөр барагдуулах дүн	Төлбөр хийх данс		Актын дүн /төгрөгөөр/	Төлбөр барагдуулах огноо
	Улсын төсвийн дансанд			
	Орон нутгийн төсвийн дансанд			
	Тухайн байгууллагын дансанд			
	Бусад			

2. Нотлох баримтын мэдээлэл

Нотлох баримтын бүрдэл			
Нотлох баримтын төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
Сүхбаатар суманд эрх шилжсэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилтийн баримт, материалууд		2017.01.01-2017.12.31	
Сүхбаатар суманд эрх шилжсэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой баримт, материалууд		2017.01.01-2017.12.31	

3. Акт /албан шаардлага/ тогтоосон Төрийн аудитын байгууллагын ажилтан болон хариуцагчийн мэдээлэл

Акт /албан шаардлага/ тогтоосон Төрийн аудитын байгууллагын ажилтан болон хариуцагчийн мэдээлэл			Хариуцагчийн мэдээлэл			
Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Танилцаж зөвшөөрсөн гарын үсэг

С.Баасансүрэн	Ахлах аудитор	<i>С.Баасансүрэн</i>	Сүхбаатар сумын ТЭЗ	Засаг дарга ЗДТГ-ын дарга	Т.Гантулга Э.Нандан-Эрдэнэ
---------------	---------------	----------------------	---------------------	------------------------------	-------------------------------

4. Акт /албан шаардлага/ тогтоох үеийн хяналт

4.1 Эхний хяналтын бүртгэл

№	Хяналт хийсэн албан тушаалтан	Хянасан огноо	Хяналтаар өгсөн зөвлөмж	Хянасан ажилтны гарын үсэг
1	Аудитын менежер			
2	Тэргүүлэх аудитор	<i>v/22.</i>	<i>Өмнө зөвлөлт-ийг дагуу гүйцэтгэх</i>	<i>Мав</i>
3	Хуулийн ажилтан			

4.2 Хяналтын баталгаажуулалт

№	Баталгаажуулсан	Зөвшөөрсөн огноо	Баталгаажуулсан гарын үсэг ба хурлын шийдвэр
1	Тэргүүлэх аудитор	<i>v/22</i>	<i>Мав</i>
2	Удирдлагын хурлын шийдвэр	<i>v/22.</i>	<i>Бат мав.</i>

43171431002
МЮА00665 9053436